



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-нийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/9/СТА-ОНӨААН

2019 он Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор:	Б.Мөнхбат
Утас: 99007576	Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер:	Д.Цэцэгмаа
Утас: 88089024	Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn
Аудитор:	Б.Цэрэнчимэд
Утас: 88302569	Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	8
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019-03-15 № 2/160
танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ
ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ
ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.БАТЦЭРЭН ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-нийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-нийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-нийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


D:\СТА-2018\Үйлдвэржилт корпораци\Тайлагнал\Аудитын-Gerchilgee.docx

2519306

"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\СТА-2018\Үйлдвэржилт корпораци\Тайлагнал\Аудитын-Gerchilgee.docx

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ний 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал С.Батцэрэн-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ий 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ий 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ий удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС/УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 05-наас 2019 оны 03 дугаар сарын 07-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ий 2018 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ний талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци нь “Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бизнесийн орчинг дэмжих замаар зах зээлийг өргөжүүлэн, ажлын байрыг нэмэгдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ний үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ний удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ий Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ний санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Виница” программ хангамж ашигладаг байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, БНА-2019/9/СТА-ОНӨААН

дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг тухайн байгууллагын хувьд байгууллагын орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэж байна.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ий 2018 оны *Нийт зардал* 201606,3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 4,032.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын хувьд алдаа зөрчил илрээгүй тул санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	50,0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	1	50,0	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулсан бөгөөд бусад хэлбэрээр алдаа, зөрчилтэй буюу залруулсан, акт, албан шаардлага өгсөн асуудал байхгүй.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй**2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

2018 онд 156263,5 мянган төгрөгийн орлого, 255856,0 мянган төгрөгийн зарлага, 99592,8 мянган төгрөгийн алдагдалтай ажиллах төлөвлөгөө батлагдаж, 138763,1 мянган төгрөгийн орлого, 239,4 мянган төгрөгийн зардал, 100600,7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК нь шилэн дансанд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээллийг улирал бүр хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100,0 хувь гүйцэтгэлтэй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ний 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ний 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ний нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

ЖДҮ-ийн төсөлд тайлант онд 400,0 сая төгрөгийн санхүүжилт олгосноос төсөл шалгарсан иргэн аж ахуйн нэгжид 395,0 сая төгрөг, зээлийн эргэн төлөлтөөс 74,6 сая төгрөг олгожээ. Мөн зорилтод бүлгийн 30 өрхөд нэгдсэн журмаар шинэ хашаа барьж, жимсний мод тарихад зориулж 50,0 сая төгрөгийг буцалтгүй олгожээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.4.1, 6.5.3, 6.5.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, өгөөж, үр нөлөөгүй зарцуулах байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

1.Төсвийн тухай хуулийн 6.5.4 "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ,тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэсэн заалтын хүрээнд зорилтод бүлгийн 30 өрхөд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний эцсийн үр дүн гартал тухайн иргэдийн оролцоог хангуулж үр дүнг тооцохын тулд төсөл хэрэгжүүлэгч Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК, гүйцэтгэгч "Өвдөгийн шанд" ГҮТББ/*Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага*/-ын гүйцэтгэх захирал Б.Отгонбилэг, тухайн өрх бүртэй гурвалсан гэрээ байгуулж ажиллах

2.Зорилтот бүлгийн 30 айлын орчинд Өвдөгийн шанд ГҮТББ-ийн гаргасан худгийг үнэлж, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК-ийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	586,634,250.35	1,058,762,721.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	55,558.00	2,034,393.39
31110	Төгрөг	55,558.00	2,034,393.39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	31,168,144.35	123,398,143.18
3121	Төгрөг	31,168,144.35	123,398,143.18
31213	Арилжааны банк дахь харилцах	31,168,144.35	123,398,143.18
33	АВЛАГА	555,410,548.00	932,939,847.08
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		14,640,410.58
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		69,870.50
336	Зээлийн авлага	555,410,548.00	918,229,566.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	555,410,548.00	918,229,566.00
33611	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	555,410,548.00	918,229,566.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	390,337.97
354	Хангамжийн материал	-	390,337.97
35410	Бичиг хэргийн материал		27,659.19
35420	Аж ахуйн материал		362,678.78
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,411,614.00	2,936,332,160.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,411,614.00	2,936,332,160.38
391	Газар		110,960,000.00
392	Биет хөрөнгө	15,411,614.00	2,824,622,160.38
39201	Барилга, байгууламж, орон сууц		2,850,478,408.33
39202	Хуримтлагдсан элэгдэл		90,703,307.87
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,698,048.00	62,868,357.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	565,434.00	8,889,630.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,310,000.00	15,590,000.00

39208	Хуримтлагдсан элэгдэл	1,031,000.00	4,721,666.65
393	Биет бус хөрөнгө	-	750,000.00
39301	Програм хангамж		1,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		250,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	602,045,864.35	3,995,094,882.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	586,837,974.57	1,059,566,589.37
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,837,974.57	49,566,589.37
413	Өглөг	557,974.57	1,515,729.37
4136	Бусад өглөг	557,974.57	1,515,729.37
41361	Байгууллагад төлөх өглөг	128,360.14	76,692.30
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		1,280,000.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	429,614.43	
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		159,037.07
414	Урьдчилж орсон орлого	26,280,000.00	48,050,860.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	26,280,000.00	46,492,800.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого		1,558,060.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	560,000,000.00	1,010,000,000.00
422	Урт хугацаат зээл	560,000,000.00	1,010,000,000.00
4221	Төгрөг	560,000,000.00	1,010,000,000.00
42212	Хувь хүмүүсийн зээл	560,000,000.00	1,010,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,207,889.78	2,935,528,292.63
51	Засгийн газрын хувь оролцоо	15,207,889.78	2,935,528,292.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,799,000.00	3,023,983,717.36
51101	Өмч: - төрийн	5,000,000.00	2,912,224,717.36
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	799,000.00	111,759,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	9,408,889.78	(88,455,424.73)
51210	Өмнөх үеийн үр дүн	9,408,889.78	9,408,889.78
51220	Тайлант үеийн үр дүн		(97,864,314.51)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	602,045,864.35	3,995,094,882.00

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	95,810,244.34	103,742,022.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	35,711,638.58
120	Нийтлэг татварын бус орлого	-	35,711,638.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	35,711,638.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,711,638.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	95,810,244.34	68,030,384.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	95,810,244.34	68,030,384.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	95,810,244.34	46,890,384.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		21,140,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	94,655,004.56	201,606,337.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	94,655,004.56	201,606,337.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,655,004.56	201,606,337.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,909,674.73	43,374,694.00
210101	Үндсэн цалин	27,909,674.73	43,374,694.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,123,470.39	12,908,110.59
210201	Тэтгэврийн даатгал	7,123,470.39	12,908,110.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,026,874.00	23,831,249.95
210301	Гэрэл, цахилгаан	4,026,874.00	23,831,249.95
2104	Хангамж, бараа материалын зардал	4,501,160.00	15,689,365.73
210402	Тээвэр, шатахуун	2,435,200.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,065,960.00	15,689,365.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,093,825.44	105,802,916.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,497,391.44	3,084,745.84
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,596,434.00	102,718,170.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,155,239.78	(97,864,314.51)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,155,239.78	(97,864,314.51)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	93,261,316.34	1,168,221,507.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,261,316.34	1,121,331,123.72
120	Нийтлэг татварын бус орлого	93,261,316.34	1,121,331,123.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,050,366,618.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,050,366,618.72
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	93,261,316.34	70,329,005.00
120014	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого /ТӨҮГ/		635,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	46,890,384.00
1330	Төсвийн захирагчдаас	-	46,890,384.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		46,890,384.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	70,455,393.99	1,074,012,673.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,455,393.99	1,074,012,673.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,528,741.12	108,061,459.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,909,674.73	43,374,694.00
210101	Үндсэн цалин	27,909,674.73	43,374,694.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,123,470.39	12,908,110.59
210201	Тэтгэврийн даатгал	7,123,470.39	12,908,110.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,026,874.00	23,831,249.95
210301	Гэрэл, цахилгаан	4,026,874.00	23,831,249.95
2104	Хангамж, бараа материалын зардал	4,501,160.00	23,814,996.00
210402	Тээвэр, шатахуун	2,435,200.00	3,293,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,065,960.00	20,521,496.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,967,562.00	4,132,409.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,967,562.00	4,132,409.35
211	ХҮҮ	22,926,652.87	965,951,213.61
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	22,926,652.87	965,951,213.61
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	22,926,652.87	965,951,213.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	22,805,922.35	94,208,834.22

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,805,922.35	94,208,834.22
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,417,780.00	31,223,702.35
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,223,702.35	125,432,536.57